



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2010 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Нийслэлийн Авто замын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 68 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллаж байгаа хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газрын бүтэц, орон тоог хавсралтад заасны дагуу шинэчлэн баталсугай.

Хоёр. Бүтэц, орон тоог шинэчлэн баталсантай холбогдуулан албан хаагчдынхаа ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, хавсралтанд дурьдсан бүтэц, орон тооны хязгаарыг чанд мөрдөн ажиллахыг Авто замын газар / Д.Од /-т үүрэг болгосугай.


Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2009 оны 14 дүгээр захирамжийн хавсралтын Авто замын газрын бүтэц, орон тооны хязгаарыг баталсан 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



Г.МӨНХБАЯР

Нийслэлийн Засаг даргын 2010 оны
~~2 дугаар~~ сарын ~~10~~ ны өдрийн
~~12 дугаар~~ захирамжийн хавсралт



АВТО ЗАМЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Газрын нэр	Хэлтэс, нэгжийн нэр	Орон тооны хязгаар
1	Авто замын газар / Шалган бүртгэх товчоо, Материал шинжилгээний лабораторитой/	Захиргааны хэлтэс	49 хүртэл үүнээс Дарга; Орлогч
		Зам барилгын хяналтын хэлтэс	
		Засвар ашиглалтын хяналтын хэлтэс	
		Төлөвлөлт судалгааны хэлтэс	
		Шалган бүртгэх товчоо	28
		Материал шинжилгээний лаборатори	13